



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/255

Арвайхээр

Түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит Сонгуулийн санал авах өдөр буюу 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн “Лхагва” гарагт аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, мөн худалдаа үйлчилгээний төвүүд гадаа болон битүү талбай (зах)-д үйл ажиллагаа явуулахыг түр хориглосугай.

2. Дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэгүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011100566